**ГАРЧИГ**

1. ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ..........4
1.1. Ерөнхий мэдээлэл ..........4
1.2. Төслийн байршил ..........5
2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..........7
3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..........8
4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..........10
5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..........11
6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..........12
7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..........13
8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..........14
9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ ..........15
10. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ ..........16
11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..........17
12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..........18
13. ДҮГНЭЛТ ..........19

# ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн талбайн булангийн цэгүүд ....5
Хүснэгт 2. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ....7
Хүснэгт 3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт ....8
Хүснэгт 4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ....10
Хүснэгт 5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө ....12
Хүснэгт 6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө ....13
Хүснэгт 7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт ....14
Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт ....15
Хүснэгт 9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт ....17
Хүснэгт 10. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт ....18

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг ........................................................6
Зураг 2. Техникийн нөхөн сэргээлт хийсэн фото зураг №1 ....................................................8
Зураг 3. Техникийн нөхөн сэргээлт хийсэн фото зураг №2 ....................................................9
Зураг 4. Техникийн нөхөн сэргээлт хийсэн фото зураг №3 ....................................................9

# 1. ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хорооны нутагт орших "Хоргын чулуу" ХХК-ийн Ар налайх шаврын ордыг ил аргаар ашиглах төслийн талбайд 2022 онд 5-10-р сар хүртэл буюу нийт 5 сар ажиллаж, 40 хүн ажилласан байна.

## 1.1. Ерөнхий мэдээлэл

| | |
|---|---|
| Төслийн нэр: | ▪ "Ар налайх шаврын орд"-ыг ил аргаар ашиглах төсөл |
| *Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын нэр:* | ▪ "Хоргын чулуу" ХХК<br>- Улсын бүртгэлийн дугаар: 9011002065<br>- Регистрийн дугаар: 5017386 |
| *Аж ахуй нэгжийн албан ёсны хаяг, утас* | ▪ Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 12-р хороо, Жанжины 29 тоот<br>▪ 976-99793322 |
| *Төслийн товч танилцуулга, хүчин чадал* | ▪ Ар налайх нэртэй MV-003978 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2017 оны 07-р сарын 25-ны өдрийн 09-р сарын 11-ний өдрийн н/75 дүгээр тушаалаар шаврын ордын нөөц нь бодитой В зэргээр 447.78 мян.$м^3$, боломжтой (С) зэргээр 780.77 мян.$м^3$ бөгөөд нийт (В+С) зэргээр 1228.55 мян.$м^3$ нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.<br>▪ Төсөлд үйлдвэрийн нөөцийг бодохдоо ашиглалтын үеийн хаягдал 2.87% (2.31 мян.$м^3$), бохирдлыг 1.91%-аар (1.54 мян.$м^3$) авч тооцсон ба ордыг эхний 10 жилийн хугацаанд ашиглах бөгөөд энэ хугацаанд 5.41 мян.$м^3$ хөрс хуулж, магадалсан В' үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэн 80.03 мян.$м^3$ шавар олборлохоор төлөвлөсөн байна. Жилийн хүчин чадал 8.0 мян.$м^3$ бөгөөд хөрс хуулалтын итгэлцүүр 0.07 $м^3/м^3$. |
| *Төслийн зорилго* | ▪ Байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар ил аргаар ашиглан олборлолт явуулахад оршино. |
| *Төслийн үргэлжлэх хугацаа* | ▪ 10 жил |

## 1.2. Төслийн байршил

Ар налайх шаврын ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Улаанбаатар хотоос зүүн тийш 33 км, Налайх дүүргээс зүүн хойш 3 км зайд байрлах ба дараах солбицлоор хязгаарлагдан байрладаг. Засаг захиргааны хувьд Налайх дүүргийн 3-р хорооны нутагт харьяалагдана.

- Талбайн хэмжээ: 25.75 гектар
- Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: L-48–10

*Хүснэгт 1. Төслийн талбайн булангийн цэгүүд*

| № | Уртраг | | | Өргөрөг | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Градус | Минут | Секунд | Градус | Минут | Секунд |
| 1 | 107 | 18 | 51.36 | 47 | 44 | 46.77 |
| 2 | 107 | 18 | 31.37 | 47 | 44 | 46.77 |
| 3 | 107 | 18 | 31.37 | 47 | 45 | 1.78 |
| 4 | 107 | 19 | 1.38 | 47 | 45 | 1.78 |
| 5 | 107 | 19 | 1.38 | 47 | 44 | 51.78 |
| 6 | 107 | 18 | 51.36 | 47 | 44 | 51.78 |




*Зураг 1. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг*

## 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 2. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | 2022 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил | **2022 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт** | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Агаарын чанар | Уурхайн гадаад тээврийн замыг чийгшүүлж байх | Уурхайн авто замын арчилгаа, тоосжилтыг бууруулах зорилгоор бид тогтмол хугацаанд усалгаа хийж байсан. | Дотоод зардал | |
| | | Уурхайг хүнд машин механизмууд, тээврийн хэрэгслийн тохиргоо үйлчилгээг байнга хийж, утааны яндангаас гарах хорт хийн хэмжээг стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй байх | Уурхайн машин механизмын засвар үйлчилгээг ажил эхлэхийн өмнө уурхайн механик инженер шалгаж, үзлэгт хамруулан гаргаж байсан. | Дотоод зардал | |
| 2 | Гадаргын ба газрын доорх усны нөөц | Унд, ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийлгэж байх | Унд, ахуйн хэрэглээний уснаас 2 сорьц авч Цаг уур, орчны шинжилгээний газар Цаг уур, орчны шинжилгээний газар Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторид шинжлүүлсэн. | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт зардал тусгагдсан | |
| 3 | Хөрсөн бүрхэвч | Хөрсөнд шатах тослох материал алдагдахаас сэргийлж гэмтэл, эвдрэлтэй машин техникийг ажлын талбайд гаргахгүй байх | Уурхайн машин механизмын засвар үйлчилгээг ажил эхлэхийн өмнө уурхайн механик инженер өдөр бүр шалгаж, үзлэгт хамруулан гаргаж байсан. | Дотоод зардал | |
| 4 | Ургамлан нөмрөг | Үйл ажиллагааны нөлөөлөлд өртөөгүй газруудад зөвшөөрөлгүй автомашин, машин механизмуудын хөдөлгөөнийг хориглох | Үйл ажиллагааны нөлөөлөлд өртөөгүй газруудад зөвшөөрөлгүй автомашин, машин механизмуудын хөдөлгөөнийг хориглож байгууллагын дотоод журам гаргаж, мөрдөж байсан. | Дотоод зардал | |
| **Нийт дүн** | | | | | **-** |

# 3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 онд MV-003978 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд байрлах эвдэрсэн газарт /0.3 га/ техникийн нөхөн сэргээлт хийсэн. Нийт 1,750,000 төгрөг зарцуулсан.

*Хүснэгт 3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт*

| № | Нөхөн сэргээлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг |
|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Техникийн нөхөн сэргээлт | Тусгай зөвшөөрлийн талбайд байх ухсан нүхийг техникийн нөхөн сэргээлт хийж, түрж тэгшлэн, шимт хөрсөөр хучиж, налуулсан. | га | 0.3 | - | 1,750,000.0 |
| **Нийт дүн** | | | | | | **1,750,000.0** |



*Зураг 2. Техникийн нөхөн сэргээлт хийсэн фото зураг №1*



*Зураг 3. Техникийн нөхөн сэргээлт хийсэн фото зураг №2*



*Зураг 4. Техникийн нөхөн сэргээлт хийсэн фото зураг №3*

# 4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| № | 2022 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил | **2022 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт** |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1 | Орон нутагтай хамтран ажиллах хүрээнд | Хоргын чулуу ХХК нь Налайхын тоосго үйлдвэрлэгчдийн холбоотой хамтран Нийслэлийн Багахангай дүүрэгт дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд нөхөн сэргээлт хийнэ. |
| | **Нийт** | **1,000,000.0** |

# 5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн олборлолтоос үүдэн нүүлгэн шилжүүлэлт болон нөхөн олговор олгох үйл ажиллагаа байхгүй. Тус ордын нөлөөллийн бүсэд айл өрхийн өвөлжөө, зуслан, гар худаг байхгүй болно.

# 6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө*

| № | Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв | 2022 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөсөн ажил | **2022 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт** | Нийт зардал |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Археологийн болон Палеонтологийн дурсгал | Хэрэв уурхайн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирвэл төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх ёстой. | MV-003978 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд соёлын биет өв илрээгүй болно. | - |
| **Нийт дүн** | | | | - |

# 7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

"Хоргын чулуу" ХХК нь 2022 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төлөвлөсөн ажлаас гадна нэмэлтээр дотоод зардлаар Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших Ар налайх нэртэй тоосгоны шаврын ордыг ил уурхайн аюулгүй үед хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөг боловсруулан ОБЕГ-ын дэргэдэх уул уурхайн аврах 09 дүгээр ангийн захирагч хурандаа Д. Гантулгаар баталгаажуулсан байна.

*Хүснэгт 6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө*

| № | Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл | 2022 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний осол эрсдэлийн менежментийн хүрээнд төлөвлөсөн ажил | **2022 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт** | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Байгалийн давтагдашгүй хүчин зүйл болох | Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах | Уурхайн ХАБЭА инженер ажилчдад байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулсан. | Дотоод зардал | |
| 2 | Галын аюул гарах | Ажиллагсдыг цахилгаан хэрэгсэлтэй харьцаж ажиллах арга ажиллагаанд сургаж, гал түймрийн үед хэрхэн ажиллах талаар сургалт зохион байгуулах | Уурхайн ХАБЭА инженер ажилчдад цахилгаан хэрэгсэлтэй харьцаж ажиллах арга ажиллагаанд сургаж, гал түймрийн үед хэрхэн ажиллах талаар сургалт зохион байгуулсан. | Дотоод зардал | |
| 3 | Осол эрсдэл үүсэх | ХАБЭА-г хамгаалах зорилгоор нийт ажилчдад ажлын хувцас, бээлий, малгайгаар хангах. | ХАБЭА-г хамгаалах зорилгоор нийт ажилчдад ажлын хувцас, бээлий, малгайгаар байнга хангадаг. | Дотоод зардал | |
| 4 | | 2022 оны уурхайн аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах. | 2022 оны Ар налайх нэртэй тоосгоны шаврын ордыг ил уурхайн аюулгүй үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан ОБЕГ-ын дэргэдэх уул уурхайн аврах 09 дүгээр ангийн захирагч хурандаа Д. Гантулгаар баталгаажуулсан байна. | Дотоод зардал | |

# 8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт*

| № | Хог хаягдлын ангилал | 2022 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд төлөвлөсөн ажил | **2022 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт** | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | | |
| 1 | Ахуйн | Дүүргийн ТҮК-тэй хийсэн хог тээрийн гэрээний дагуу зайлуулах | Шингэн хог хаягдлыг 2022 оны 05-р сарын 28-ны өдрийн Б/09 дугаартай Чандмань налайх ОНААҮГ-тэй хийсэн гэрээний дагуу тогтмол хугацаанд соруулж байсан. | - | 110,220.0 |
| 2 | Үйлдвэрийн | | Хатуу хог хаягдлыг 2022 оны 05-р сарын 26-ны өдрийн 2205010 дугаартай Налайх “Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-тэй хийсэн хог хаягдлыг ачиж тээвэрлэх гэрээний дагуу тогтмол хугацаанд ачуулж байсан. | - | 396,000.0 |
| 3 | Шингэн хог хаягдал | Хаягдал бохир усыг “Ирвэс Интертрейд” ХХК-ийн худалдаалж буй “Тамир-Эм” био бэлдмэлээр сар тутам ариутгаж, бие засах газар луу зайлуулах | Хаягдал бохир усыг “Ирвэс Интертрейд” ХХК-ийн худалдаалж буй “Тамир-Эм” био бэлдмэлээр сар тутам ариутгаж, бие засах газар луу зайлуулж байсан | - | Дотоод зардал |
| 4 | | Хаягдал усыг байгальд шууд нийлүүлж байгаа хуулийн этгээдтэй байгуулах ус бохирдуулсны төлбөрийн гэрээ хийх | Налайх дүүргийн хот төлөвлөлт Ногоон хөгжлийн чиглэлийн төсөл хөтөлбөрийн удирдагч бөгөөд Засаг даргын орлогчтой 2022 оны 6 сарын 21-ны өдрийн 03 дугаартай Хаягдал усыг байгальд шууд нийлүүлж байгаа хуулийн этгээдтэй байгуулах ус бохирдуулсны төлбөрийн гэрээ хийсэн. | - | 35,000.0 |
| **Нийт дүн** | | | | | **541,220.0** |

# 9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

*Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт*

| № | 2022 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг |
|---|---|---|---|
| | 3 | 4 | 5 |
| | Агаарын чанар | | |
| 1 | Агаарын чанар болон дуу шуугианы хэмжилтийг 1 удаагийн давтамжтай 2 цэгээс авч Цаг уур, орчны газар Байгаль орчны хэмжилзүйн төв лабораторид шинжлүүлсэн (шинжилгээний үр дүнг хавсралтаар хавсаргав). | 31,900.0 | 63,800 |
| | Хөрсөн бүрхэвч | | |
| 2 | 1 цэгээс хөрсний хүнд металлын нэг дээж авч Цаг уур, орчны газар Байгаль орчны хэмжилзүйн төв лабораторид шинжлүүлсэн (шинжилгээний үр дүнг хавсралтаар хавсаргав). | 39,600 | 39,600 |
| | Усны чанар | | |
| 3 | Унд, ахуйн хэрэглээний худгийн уснаас усны сорьц авч Цаг уур, орчны газар Байгаль орчны хэмжилзүйн төв лабораторид шинжлүүлсэн (шинжилгээний үр дүнг хавсралтаар хавсаргав). | 55,000.0 | 55,000.0 |
| **Нийт дүн** | | | **158,400.0** |

# 10. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ШААРДЛАГААР БИЕЛҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Хот төлөвлөлт, үйлдвэрлэл, ногоон хөгжлийн төсөл хөтөлбөрийн удирдагч бөгөөд Налайх дүүргийн Засаг даргын орлогчтой 2021 оны 11 сарын 17-ны өдөр "Хоргын чулуу" ХХК нь Нийгмийн хариуцлагын гэрээ байгуулсан.

Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Инновац, гарааны бизнес, оюуны үйлдвэрлэлийг дэмжих инновацын төв байгуулна" заалтын хүрээнд залуусын бизнес сэтгэлгээг хөгжүүлэх, гарааны бизнес эхлүүлэх шинэ шинэлэг санааг нээж олох, ажиллаж суралцахад таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн 54 $м^2$ талбайг бүрэн засварлаж, "Цагаан хулан" ХХК-иар /Сайн тавилга/ компьютерын ширээ, суудалтай номын сан, кофены хэсэг, хувцасны шкаф, 10 хүний суудалтай ширээ зэрэг иж бүрэн тавилгыг захиалгаар хийлгэн тохижуулсан.

Тус ажлыг нийгмийн хариуцлагын хүрээнд дүүргийн "Тоосго үйлдвэрлэгчдийн Титэм холбоо"-ны гишүүн байгууллагуудтай хамтран хийж гүйцэтгэсэн. Манай компани нь нийт **2,000,000** төгрөгийн дэмжлэг үзүүлсэн (төлбөрийн баримт, Налайх дүүргийн Засаг даргын тамгын газрын худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн илтгэх хуудсыг хавсралтаар хавсаргав).

Мөн нийгмийн хариуцлагын хүрээнд манай компани нь Налайх дүүрэгт зохион байгуулсан "Төвийн бүсийн хурдан морины уралдаан"-д нийт **5,000,000** төгрөгийн дэмжлэг үзүүлсэн (төлбөрийн баримт, Налайх дүүргийн Засаг даргын тамгын газар хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн илтгэх хуудсыг хавсралтаар хавсаргав).

# 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт*

| № | 2022 онд хэрэгжүүлэх БОМТ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төлөвлөсөн ажлууд | **2022 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт** |
|---|---|---|
| 1 | Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх | Нийгмийн хариуцлагын хүрээнд дүүргийн “Тоосго үйлдвэрлэгчдийн Титэм холбоо”-ны гишүүн байгууллагуудтай хамтран инновацын төвийг тохижуулсан.<br>Мөн дүүрэгт зохион байгуулсан “Төвийн бүсийн хурдан морины уралдаан”-д дэмжлэг үзүүлсэн. Нийт **7,000,000.0** төгрөг зарцуулсан. |
| 2 | Эвдэгдсэн талбайн хэмжээг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хэмжүүлэх | “Сод Сүрвей” ХХК-иар маркшейдерийн хэмжилтийн тайланг **500,000.0** төгрөгөөр хийлгэсэн. |
| 3 | Усны нөөц ашигласны төлбөр төлөх | Ус ашиглах гэрээ байгуулж, усны төлбөр **544,820** төгрөг тушаасан. |
| 4 | Газрын төлбөр төлөх | Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны даргатай 2022 оны 4 сарын 29-ны өдрийн №01113-2021/02740 дугаартай Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээг байгуулсан. Нийт **7,391,536.0** төгрөг төлсөн. |
| 5 | БОННҮ-р тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах, зөвлөмж, батлагдсан БОМТ-нд үндэслэн тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах | Байгаль орчны үнэлгээний мэргэжлийн байгууллага “Баялаг Баян Ундарга” ХХК-тай хамран ажиллах гэрээ байгуулан БОАЖСайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 дугаар тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу БОМТ-г боловсруулж байгаа билээ. |
| **Нийт дүн** | | **15,436,356** |

# 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 10. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт*

| № | БОХТ-ний биелэлтийг тайлагнах төлөвлөгөө | Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийг бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт |
|---|---|---|
| 1 | Нийслэлийн байгаль орчны газарт тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүргүүлэх | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хэвлэмэл хэлбэрээр 2022 оны 11-р сарын 01-ны өдөр хүргүүлсэн. |
| **Нийт дүн** | | **50,000** |

# 13. ДҮГНЭЛТ

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт байрлах “Хоргын чулуу” ХХК-ийн Ар налайхын шаврын ордыг ил аргаар ашиглах төслийн 2022 онд хэрэгжүүлсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн үр дүнд бид дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- 2022 онд хэрэгжүүлсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 – ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 1 дүгээр хавсралтад заасан аргачлалын дагуу боловсруулав;
- “Хоргын чулуу” ХХК нь 2022 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэд нийт **23,935,976.0** төгрөг зарцуулсан байна;

# Хавсралт

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.

# МОНГОЛ УЛС
# УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

0000111896

2005.09.12
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011002065
/ Улсын бүртгэлийн дугаар /

5017386
/ Регистрийн дугаар /

Хоргын чулуу    Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

| Шийдвэр | 01 | 2005.09.12 |
|---|---|---|
| / шийдвэрийн нэр / | / дугаар / | / он, сар, өдөр / |

4721    Хүнсний дэлгүүр
/ код /    / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

/ код /    / Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

| Хугацаагүй | 1 | 1 000,00 |
|---|---|---|
| / хугацаа / | / гишүүдийн тоо / | / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр / |

Улаанбаатар, Баянзүрх, 12-р хороо, Жанжины 29 тоот, Утас1: 99793322, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Улсын бүртгэлийн ерөнхий
газрын Бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон    2015 он 12 сар 16 өдөр

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | *Бүрэндээ овогтой Мөнх-Эрдэнэ-г Захирал-р томилсныг бүртгэв.* | *2005.09.12* | *Ж.Төмөрсүх* |
| 2 | *Дахин гэрчилгээ олгов.* | *2015.12.16* | *О.Шижиртуяа* |
| 1 | *Улаанбаатар, Налайх, 6-р хороо, , , , Эрээний адаг гудамж тоот, Утас1 99112662, Утас2 88228844. Факс хаягийг шинээр бүртгэв.* | *2018.10.26* | *Ж.Оюумаа* |
| 3 | *4610 Гадаад худалдаа эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв.<br>0899 Ашигт малтмал ашиглах /2017.12.20-2018.12.20/ хүртэл эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв.<br>4100 Барилга угсралт 2.1.1, 2.1.2, 2.1.3, 2.2.1, 2.2.2 /2018.01.25-2023.01.25 хүртэл/ эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв.<br>4390 Материалын үйлдвэрлэл /2018.03.20-2021.03.20 хүртэл/ эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв.* | *2018.10.26* | *Ж.Оюумаа* |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

*0001115 96*

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗАР

# АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

*Дугаар 3978А*

Ашигт малтмалын тухай Монгол улсын хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн

Улаанбаатар аймаг /хот/-ийн

Налайх сум /дүүрэг/-ын

Налайх нэртэй газарт орших

25 гектар талбай бүхий уурхайн талбайд хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг зөвшөөрч улсын бүртгэлийн 9011002065 тоот гэрчилгээтэй

Хөргын чулуу ХХК -д

энэхүү тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Л. БОЛД

*2007 оны 02 сарын 12 өдөр*

*Улаанбаатар хот*

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

MV-003978

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

| Дэс дугаар | Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл | Огноо, гарын үсэг, тэмдэг |
|---|---|---|
| 019-PE | • Бүртгэв: 9016001011 тоот улсын бүртгэлийн дугаартай ХААН Банкны барьцаанаас чөлөөлөх<br>• Кадастрын хэлтсийн даргын 2014.11.18-ны 510 тоот шийдвэр | 2014-11-18 |
| 020-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 14 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2014.12.20 – 2015.12.20 хүртэл | 2014-12-18 |
| 021-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 15 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2015.12.20 – 2016.12.20 хүртэл | 2015-12-15 |
| 022-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 16 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2016.12.20 – 2017.12.20 хүртэл | 2016-12-20 |
| 023-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 17 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2017.12.20 – 2018.12.20 хүртэл | 2017-12-15 |
| 024-FE | • Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 18 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2018.12.20 – 2019.12.20 хүртэл | 2018-12-19 |
| | | |

0003244

# БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар... МҮ 13-014/18

"Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" Монгол Улсын хуулийг үндэслэн ........ Улаанбаатар ........ аймаг/нийслэлийн

........ Баянзүрх ........ сум/дүүргийн

........ " Хоргын чулуу " ХХК ........ -д

9011002065 ........ 5017386

*/улсын бүртгэлийн дугаар/* *<br>/регистрийн дугаар/*

Материалын үйлдвэрлэл: 8.1 заалтын дагуу ........

........ ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 2018 оны 03 -р сарын 20 -ны өдрөөс гурван ..... жилийн хугацаатай олгов.

Тусгай зөвшөөрөл нь хавсралт болон гэрээний хамт хүчинтэй.

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД** **Х.БАДЕЛХАН**

2018 он 03 сар 20 өдөр

Улаанбаатар хот

***Ажил, үйлчилгээний төрөл:***

МҮ-8.1 Керамик тоосго, гулдмайн үйлдвэр

(Хатаах камер/талбайн хатаагуур хосолсон керамик тоосгоны үйлдвэрлэл)

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хаяг: Налайх дүүрэг, 3-р хороо

Компанийн захирал /эзэн/ Б. Мөнх-Эрдэнэ */овог, нэр/*

Утас: 88228844 Факс: 80889940 И-мэйл: erenbat.2016@gmail.com

БУI2-304/I8 ........дугаар гэрчилгээний хавсралт
Гэрчилгээний хамт хүчинтэй.

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ**
**БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ**

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ

| Гэрээ дүгнэсэн тэмдэглэл | Албан тушаалтны гарын үсэг, тэмдэг |
|---|---|
| | |
| | |
| | |
| | |
| | |
| | |
| | |
| | |
| | |
| | |
| | |
| | |
| | |
| | |

# АЖ АХУЙН НЭГЖ "ХОРГЫН ЧУЛУУ"ХХК ( 5017386 ) - ИЙН
# АШИГЛАЖ БАЙГАА ГАЗРЫН БАЙРШЛЫН КАДАСТРЫН ЗУРАГ

Нэгж талбарын дугаар:

Хаяг: УБ хот, Налайх дүүрэг, 3-р хороо

Огноо: 2018-04-05




Зургийн масштаб 1:10000 (1 сантиметрт 100 метр багтана)

Хэмжилтийн ажлыг тулгуурлан гүйцэтгэсэн үндэслэлийн цэгүүд

| Цэг | X | Y | Y |
|---|---|---|---|
| 0950 | 5296080.791 | 669891.181 | 1462.018 |
| 0949 | 5295813.394 | 669542.427 | 1453.522 |

Хашааны координат:

| Дугаар | X | Y | Өндөр | Урт | Цэгүүд |
|---|---|---|---|---|---|
| 1 | 5290699.770 | 673474.250 | 1429.665 | 416.61 | 1-2 |
| 2 | 5290687.330 | 673057.830 | 1427.656 | 463.57 | 2-3 |
| 3 | 5291150.690 | 673044.000 | 1430.847 | 625.06 | 3-4 |
| 4 | 5291169.370 | 673668.780 | 1422.965 | 308.84 | 4-5 |
| 5 | 5290860.670 | 673678.030 | 1431.666 | 208.50 | 5-6 |
| 6 | 5290854.430 | 673469.620 | 1433.050 | 154.73 | 6-1 |

Талбайн хэмжээ: 257510.5 квадрат метр

Зураг үйлдсэн: "Хишигт хөндий" ХХК-ны инженер

........................ Отгонцэцэг

(хэмжилт хийсэн байгууллага, мэргэжилтний нэр)

Шалгасан: ........................ Б.Батхишиг

Хянасан: ........................ / /

(дүүрэг, сумын газрын албаны мэргэжилтний нэр, гарын үсэг)

(Тамга)

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**
**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР**
**ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН**

# ДҮГНЭЛТ

2018 оны 10 сарын 23 өдөр Дугаар T/18-13-16 Улаанбаатар хот

*Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших MV-003978 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Ар налайх шаврын ордыг ил аргаар ашиглах төслийн техник-эдийн засгийн үндэслэлийг хэлэлцсэн тухай*

"Хоргын чулуу" ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн "Жеммери" ХХК боловсруулсан Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших Ар налайх шаврын ордыг ил аргаар ашиглах төслийн техник-эдийн засгийн үндэслэлд Монгол улсын уул уурхайн зөвлөх инженер Б.Эрдэнэцэцэг зөвлөж, уул уурхайн мэргэшсэн инженер Ж.Ижилмаа шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Техник-эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Техник-эдийн засгийн үндэслэл нь Тусгай зөвшөөрлийн талбайн ерөнхий мэдээлэл, Уул-технологийн хэсэг, Боловсруулах хэсэг, Цахилгаан хангамж, Усан хангамж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ,нөхөн сэргээлт, Төслийн эдийн засаг зэрэг 8 бүлэг, дүгнэлт, хавсралт материал, хавсралт тооцоо бүхий 88 хуудас тайлбар бичиг, 9 хавсралт зургуудаас бүрдэж байна.

2. Ар налайх нэртэй MV-03978 тоот тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2017 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн хурлын ХХ-13-06 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан АМГТГ-ын даргын 2017 оны 09 дугаар сарын 11-ний өдрийн н/75 дүгээр тушаалаар шаврын ордын нөөц нь бодитой B зэргээр 447.78 мян.$м^3$, боломжтой (C) зэргээр 780.77 мян.$м^3$ бөгөөд нийт (B+C) зэргээр 1228.55 мян.$м^3$ нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

3. Төсөлд үйлдвэрлэлийн нөөцийг бодохдоо ашиглалтын үеийн хаягдал 2.87% (2.31 мян.$м^3$), бохирдлыг 1.91%-аар (1.54 мян.$м^3$) авч тооцсон ба ордыг эхний 10 жилийн хугацаанд ашиглах бөгөөд энэ хугацаанд 5.41 мян.$м^3$ хөрс хуулж, магадалсан B' үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэн 80.03 мян.$м^3$ шавар олборлохоор төлөвлөсөн байна. Жилийн хүчин чадал 8.0 мян.$м^3$ бөгөөд хөрс хуулалтын итгэлцүүр 0.07 $м^3/м^3$.

4. Ар налайх нэртэй шаврын ордыг ашиглахад эдийн засгийн үр ашигтай нөөцөд тулгуурлан ил уурхайн зардал, бүтээгдэхүүн борлуулах үнийн дагуу буюу 100-150 маркийн тоосгыг 195.0 төг-өөр борлуулах эдийн засгийн тооцоог хийж ТЭЗҮ-ийг боловсруулсан байна.

5. Уурхайн ашиглалтын системийн сонголтыг хийхдээ ордын нөөцийн тогтоц болон байршил, хөрсний зузаан, хөрсний чулуулгийн шинж чанар, зэргийг харгалзан үзэж

000957

авто тээвэртэй ашиглалтын системээр ашиглах нь оновчтой гэж үзжээ. (Жилийн хүчин чадал нь 8.0 мян.$м^3$)

6. Тус уурхайд Hyundai R220LC маркийн экскаватор 1ш, 25 тн даацтай Howo автосамосвал 1ш, SDLG LG953 маркийн дугуйт ачигч 1ш, зэрэг үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар ТЭЗҮ-д тусгажээ.

7. Ордын туршилт судалгаа, шаврын физик механикийн шинж чанар, шаврын хураангуй шинжилгээ, эрдсийн, технологийн, шаталтын, химийн, шинжилгээнүүдийг "БАК"-ийн итгэмжлэгдсэн лабораторид, цацрагийн шинжилгээг цөмийн болон цацрагийн хяналт газрын цацрагийн хяналт шинжилгээний лабораторид тус тус туршилт судалгааны ажил хийгдсэн байна.

8. Туршилтын үр дүнгээр, шаврын технологийн шинжилгээний болон шатаалтын туршилтаас үзэхэд хатаалтын үеийн агшилт дунджаар 6.99% бөгөөд $900^0$с хэмийн шатаалтын үеийн дундаж агшилт 1.64% ерөнхий агшилт 8.63%, ус шингээлт 14.2%, дундаж нягт 1.72% г/$см^3$, шахалтын бат бэх 210.2 кг/см2, гулзайлтын бат бэх 200.0 кг/$см^2$, хүйтэн тэсвэрлэлт (сульфат тэсвэрлэлт)-ийн итгэлцүүр 0.95 байна. шаврыг шатааж 100-150 маркийн тоосго хийх боломжтой гэж шинжилгээний үр дүнгээр тогтоосон байна.

9. Олборлолтын явцад техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлуудыг MNS5915:2008, MNS5916:2008, MNS5918:2008, MNS5850:2008 зэрэг Монгол улсын стандарт зааварчилгааны дагуу гүйцэтгэж, уулын ажлын үр дүнд үүссэн ухашийг нөхөн дүүргэж тэгшлэх, тухайн бүсийн уур амьсгалын нөхцөл байдалд тохирсон мод, бутлаг ургамлаар биологийн нөхөн сэргээлтийн ажлуудыг хийж гүйцэтгэхээр зардлыг төсөлд тусгасан байна.

10. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт ба хаалтын зардалд эхний 10 жилд 84.3 сая.төгрөг зарцуулахаар тооцсон байна. Үүнээс байгаль орчин хамгаалах зардалд 42.0 сая.төгрөг, техникийн нөхөн сэргээлтийн зардалд 14.76 сая.төгрөг, биологийн нөхөн сэргээлтийн зардалд 6.37 сая.төгрөг, бэлтгэл ажлын зардалд 13.0 сая.төгрөг, төслийн хаалтын зардалд 8.17 сая.төгрөг зарцуулахаар тусгажээ.

11. Уурхайн эхний 10 жилийн хөрөнгө оруулалтын хэмжээ 492.7 сая.төгрөг ба 100-150 маркийн тоосгыг 195 төг-өөр борлуулахаар тооцон төслийн эхний 10 жилийн хугацаанд 4.87 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 3.60 тэрбум төгрөгийн ашиглалтын зардал гарган, 1.14 тэрбум төгрөгийн цэвэр ашиг олж, хөрөнгө оруулалтаа ашиглалтын 4.3 жилийн хугацаанд нөхөхөөр тооцжээ.

12. Төслийн эхний 10 жилийн хугацаанд нийт 718.8 сая төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болох бөгөөд 10%-ийн хорогдуулалтын норм тооцсон өнөөгийн цэвэр үнэ цэнэ 214.2 сая.төгрөг, өгөөжийн дотоод норм 20% гарсан нь төсөл эдийн засгийн хувьд үр ашигтайгаар хэрэгжих боломжтой гэж үзжээ.

13. Төсөл хэрэгжсэнээр улс, орон нутгийн төсөвт 970.6 сая.төгрөгийг татвар төлбөр хэлбэрээр төвлөрүүлэх ба 33 хүний ажлын байр шинээр бий болохоор төсөлд тусгажээ.

14. Төсөлд шаардлагатай мэргэжлээр Монгол улсын иргэдийг бэлтгэх, тэдгээрийг ажлын байраар хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж байгаль орчныг нөхөн сэргээх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байхыг ЭБМЗ-өөс даалгаж байна.

15. Техник, эдийн засгийн үндэслэл нь уншихад ойлгомжтой, цэгц дараалал сайтай, мэргэжлийн түвшинд чанартай сайн боловсруулсан, уурхайг эхлэн байгуулж үйлдвэрлэл явуулах бүхий л шат дамжлага буюу үйл ажиллагааг хамарсан, уулын ажлын төлөвлөгөө боловсруулах зэрэгт туслах үндсэн баримт бичиг болжээ.

16. Энэхүү техник, эдийн засгийн үндэслэл нь ЭБЭХ-ийн сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074-р тушаалаар баталсан "Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам"-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.

17. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, цахилгаан болон усан хангамж, дэд бүтэц, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, төслийн эдийн засгийн үнэлгээг боловсруулсан Уул уурхайн зураг төслийн "Жеммери" ХХК хариуцах, түүний үнэн бодит байдал, чанарт гаргасан дүгнэлтийг шинжээч Уул уурхайн мэргэшсэн инженер Ж.Ижилмаа хариуцах.

18. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан уурхайн хүчин чадал, техник тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж, ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж байх нь зүйтэй.

19. Захиалагч компани Техник-эдийн засгийн үндэслэлийг хүлээн авах тухай Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын шийдвэр гарснаас хойш 5 хоногт багтаан Техник-эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвд холбогдох шаардлагад нийцүүлэн хүлээлгэн өгөх үүрэгтэй. Энэ үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын дарга гаргасан шийдвэрээ түдгэлзүүлэх, цуцлах эрхтэйг анхааруулах нь зүйтэй.

Техник-эдийн засгийн үндэслэлд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Салбар хуралдаанаас Ашигт малтмал, газрын тосны газрын даргад Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн " Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших MV-003978 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Ар налайх шаврын ордыг ил аргаар ашиглах төслийн техник-эдийн засгийн үндэслэл"-ийг хүлээн авах шийдвэр гаргахыг уламжлахаар шийдвэрлэв.

ТАНИЛЦСАН:
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Б.ДЭЛГЭРЖАРГАЛ

ХТО 0206

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Б.ЭЛБЭГЗАЯА

БОЛОВСРУУЛСАН:
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА С.ГАН-ОЧИР

ЭБМЗ-ийн V/18-13-16 дугээр дүгнэлтийн хавсралт

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших MV-003978 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "ар налайх" нэртэй шаврын ордын үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо

| № | Нөөцийн зэрэглэлийн блокийн дугаар | Ашигт малтмалын геологийн нөөцийн хэмжээ | | Дундаж зузаан | | Уурхайн 10 дахь жилийн хүрээ хязгаарт орох нөөцийн хэмжээ | | | Ашиглалтын хаягдал | | Бохирдол | | Үйлдвэрлэлийн нөөцийн зэрэг /Магадлагдсан B'/ | Үйлдвэрлэлийн нөөц | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Шавар, $м^3$ | Хөрс, $м^3$ | Шавар, м | Хөрс, м | Талбай, $м^2$ | Шавар, $м^3$ | Хөрс, $м^3$ | Шавар, % | Шавар, $м^3$ | Хөрс, % | Хөрс, $м^3$ | | Шавар, $м^3$ | Хөрс, $м^3$ |
| 1 | B - I | 109069.2 | 6059.4 | 5.4 | 0.3 | 2979.8 | 15569.5 | 893.9 | 2.87% | 446.9 | 1.91% | 298.0 | B-1' | 15420.5 | 1042.9 |
| 2 | B - II | 122145.0 | 7185.0 | 5.1 | 0.3 | 0.0 | 0.0 | 0.0 | 2.87% | 0.00 | 1.91% | 0.0 | B-2' | 0.0 | 0.0 |
| 3 | B - III | 105856.9 | 5991.9 | 5.3 | 0.3 | 12485.5 | 65236.7 | 3745.7 | 2.87% | 1872.8 | 1.91% | 1248.5 | B-3' | 64612.5 | 4369.9 |
| 4 | B - IV | 110710.8 | 6512.4 | 5.1 | 0.3 | 0.0 | 0.0 | 0.0 | 2.87% | 0.00 | 1.91% | 0.0 | B-4' | 0.0 | 0.0 |
| 5 | C - I | 455574.8 | 29711.4 | 4.6 | 0.3 | 0.0 | 0.0 | 0.0 | 2.87% | 0.00 | 1.91% | 0.0 | B-5' | 0.0 | 0.0 |
| 6 | C -II | 325201.5 | 21680.1 | 4.5 | 0.3 | 0.0 | 0.0 | 0.0 | 2.87% | 0.00 | 1.91% | 0.0 | B-6' | 0.0 | 0.0 |
| **Нийт нөөц B+C** | | **1228558.2** | **77140.2** | 5.0 | 0.3 | 15465.3 | 80806.2 | 4639.6 | 2.87% | 2319.8 | 1.91% | 1546.5 | - | 80032.9 | 5412.9 |
| **Нийт бодитой нөөц - B** | | **447781.9** | **25748.7** | **5.2** | **0.3** | **15465.3** | **80806.2** | **4639.6** | **2.87%** | **2319.8** | **1.91%** | **1546.5** | **-** | **80032.9** | **5412.9** |
| **Нийт боломжтой нөөц - C** | | **780776.3** | **51391.5** | 4.6 | 0.3 | 0.0 | 0.0 | 0.0 | 2.87% | 0.00 | 1.91% | 0.0 | - | 0.0 | 0.0 |

**Хянасан:**
Металл бус ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөн,
бүртгэл хариуцсан мэргэжилтэн ................................................ /Д.Эрдэнэтунгалаг/

**Боловсруулсан:**
Уул уурхайн зураг төслийн "Жеммери" ХХК-ийн
Төслийн инженер ................................................ /Н.Мөнхсүх/

"ЖЕММЕРИ" ХХК
УЛААНБААТАР ХОТ

**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 09 сарын 11 өдөр Дугаар Н/75 Улаанбаатар хот

Нөөцийг хүлээн авч, бүртгэх тухай

Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4. дэх хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны 23 дугаар тушаалаар батлагдсан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрмийн 3.1 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2017 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны ХХ-13-06 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших MV-003978 дугаартай тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах “Ар налайх” нэртэй шаврын ордын нөөцийг зохиогчийн тооцоолсон хувилбараар хүснэгт №1-ийн дагуу хүлээн авсугай.

2. Хүлээн авсан шаврын нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төв /Г.Золсайхан/-д зөвшөөрсүгэй.

3. Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дахь “Ар налайх” нэртэй шаврын ордод 2013 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайланг, тайлангийн бичвэр дискийн хамт ЭБМЗ-ийн хуралдааны дүгнэлт, тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн архивт хүлээлгэн өгөхийг “Хоргын чулуу” ХХК /Б.Мөнх-Эрдэнэ/-д даалгасугай.

ДАРГА Б.БААТАРЦОГТ

10 1115

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**
**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР**
**ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ**

*2017.07.25* *Улаанбаатар хот*

*Дугаар: ХХ-13-06*

*Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших MV-003978 дугаар тусгай зөвшөөрөлтэй Ар налайх талбайд 2013 онд гүйцэтгэсэн шаврын ордын хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хэлэлцсэн тухай.*

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дахь Ар налайх шаврын ордод 2013 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгээр геологич С.Алтангэрэл, Л.Бадамтулга, Д.Өгөөдэй нарын боловсруулан тайлан, уг тайлан дахь нөөцийн тооцоонд Монгол Улсын зөвлөх инженер, геологич Н.Зинэмэдэр, түүхий эдийн чанарт барилгын материалын зөвлөх инженер Н.Оч нарын хийсэн дүгнэлтийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцээд, ДҮГНЭЛТ гаргав.

1. Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дахь Ар налайх нэртэй 25 га талбайн MV-003978 дугаар тусгай зөвшөөрлийг АМГТХЭГ-ын ГУУКА-наас 2001 оны 12 сарын 20-ны өдөр "Дина" ХХК-д олгосон бөгөөд 2005 оны 11 сарын 10-ны өдөр "Хоргын чулуу" ХХК шилжүүлэн авч, далд аргаар нүүрс олборлох үйл ажиллагаа явуулж байсан.

"Хоргын чулуу" ХХК нь дээрх талбайд 2013 онд өөрийн хөрөнгөөр хайгуулын ажил гүйцэтгэж, шаврын бодитой (B) нөөцийг тогтоон, хайгуулын ажилд нийт 19 сая төгрөг зарцуулсан байна.

2. Ар налайх талбай нь Улаанбаатар хотоос зүүн тийш 45 орчим км, Налайх дүүргээс зүүн хойш 3 км орчим зайд орших бөгөөд дэд бүтэц сайн хөгжсөн нутагт байрлана.

3. Ордын дүүрэгт геологийн судалгаа нүүрс, шаврын хайгуул, геологийн зураглал чиглэлээр 1940 оноос эхэлсэн бөгөөд хайгуулын талбайг хамарсан нүүрсний хайгуулыг Р.Миземхан нар 1970-1976 онд хийсэн байна.

4. Хайгуулын ажлаар 2.7 т/км эрлийн маршрут, 25 га талбайд геологийн зураглал болон байр зүйн зураглал, 66 т/м өрөмдлөг, 19 ш сорьцлолтын ажлууд хийж, лабораторийн физик механикийн шинжилгээнд 16 ш, технологийн шинжилгээнд 3 ш, химийн шинжилгээнд 2 ш, рентгендифрактометрийн шинжилгээнд 2 ш, цацраг идэвхт элементийн шинжилгээнд 2 ш сорьц хамруулсан байна.

5. Орд нь доод цэрдийн Зүүнбаян формацын амьтан ургамлын үлдвэр бүхий хөрзөн, хайргажин, элсжин, алевролит, аргиллит, шавар, нүүрсний давхарга, голоцений салхины гарал үүсэлтэй, элс, элсэнцэрээс бүрдсэн ба шавар нь эх газрын уулс хооронд хуримтлагдсан доод цэрдийн тунамал хурдас бөгөөд литологи, найрлагаараа ордын аль ч хэсэгт харьцангуй жигд, тогтвортой, хэвтээ байрлалтай, давхарга хэлбэрийн хуримтлал үүсгэн, баруунаас зүүн тийш 625 м сунасан, 310-460 м өргөнтэйгээр тархжээ.

6. Ордын шаврын ширхгийн бүрэлдэхүүнд >63 мк-ийн хэмжээтэй нь дунджаар 25.42%, 63-20 мк-ийн хэмжээтэй нь дунджаар 11.17%, 20-6.3 мк-ийн хэмжээтэй нь дунджаар 11.66%, 6.3-2 мк-ийн хэмжээтэй нь дунджаар 13%, 2 мк>-ийн хэмжээтэй нь дунджаар 38.75% байгаа нь тогтоогдсон ба үүнээс элсэрхэг хэсэг нь ордын дунджаар 36.59%, тоосорхог хэсэг 24.66 %, шаварлаг хэсэг 38.75 %-ийг эзэлнэ.

"Ар налайх" ордын тоосгоны хатаалтын үеийн агшилт дунджаар 6.99% бөгөөд $900^0$С хэмийн шатаалтын үеийн дундаж агшилт 1.64%, ерөнхий агшилт 8.63%, ус шингээлт 14.2 %, дундаж нягт 1.72 г/$см^3$, шахалтын бат бэх 210.2 кг/$см^2$, гулзайлтын бат бэх 200.0 кг/см2, хүйтэн тэсвэрлэлт (сульфат тэсвэрлэлт)–ийн итгэлцүүр 0.95 байна.

Шаврын химийн найрлагаар CaO 5.55%, MgO 1.15%, SO 0.28%, радийн эквивалентийн хэмжээ дунджаар 127.5 Бк/кг гэж тогтоогдсон нь шаардлагад нийцэж байгаа.

7. Зохиогчид нийт шаврын бодитой ба боломжтой (В+С) нөөц нь 1228558 $м^3$, үүнээс бодитой (В) нөөц нь 447782 $м^3$, боломжтой (С) нөөц нь 780776 $м^3$ гэж тогтоон, ашиглалт явуулж байсан 6 аманд нүүрсний илрүүлсэн баялаг $P_2$ зэргээр 8400 тн гэж үнэлсэн байна.

Ордыг ашигт малтмалын тогтоц, зузаан ба чанарын хувьд тогтвортой учир I бүлгийн ордод хамааруулжээ.

8. Шинжээч дээрх нөөцийн тооцоонд хяналтын тооцоо хийж, ордын нөөцийг зохиогчийн тооцоолсон хувилбараар хүлээж авахыг санал болгосон ба ЭБМЗ-ийн хуралдааны үед Зөвлөлийн гишүүдийн саналаар ордын нөөцийг зохиогчийн тооцоолсон хувилбараар ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэх нь зүйтэй гэж үзэв.

9. "Ар налайх" шаврын ордын техник эдийн засгийн урьдчилсан үнэлгээгээр 468000.0 мян.төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, эхний 5 жилд нийт 45000 $м^3$ шавар олборлох бөгөөд 1 ширхэг тоосгоны борлуулалтын үнийг 270.0 төгрөгөөр тооцоход нийт борлуулалтын орлого 6 075.0 мян.төгрөг, ашиглалтын зардал 2 042.0 мян.төгрөг, 1 ширхэг тоосгоны өөрийн өртөг 130.0 төгрөг, хөрөнгө оруулалтаа 1 жилийн дотор нөхөх боломжтой байна.

10. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон ордыг ашиглах ТЭЗҮ-ийг бодитой болон боломжтой нөөцөд тулгуурлан, эрх бүхий хуулийн этгээдээр хийлгэх, холбогдох хууль тогтоомж, ялангуяа Ашигт малтмалын тухай хууль түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан заавар, журмуудыг мөрдөж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид анхааруулахаар тогтов.

*Тайлан зохиогчдын илтгэл, тайлбар, шинжээчийн дүгнэлт, Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаас дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:*

а. "Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дахь Ар налайх шаврын ордод 2013 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан" дахь шаврын бодитой ба боломжтой (В+С) нөөцийг 1228558 $м^3$ буюу 1981176 тн гэж зохиогчийн тооцоолсон хувилбараар хүлээн авах. /Ордын нөөц 2017 оны 1 сарын 01-ний байдлаар/

б. Хуралдааны энэхүү дүгнэлтийн дагуу хүлээн авсан “Ар налайх” ордын шаврын геологийн нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төв /Г.Золсайхан/-д зөвшөөрөх.

в. Энэхүү дүгнэлтийн 10 дугаар заалтыг цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг “Хоргын чулуу” ХХК-д анхааруулах.

г. Хайгуулын ажлын үр дүнгийн тайланг, хээрийн судалгааны анхдагч материал, тайлангийн бичвэрийг дискийн хамт ЭБМЗ-ийн хуралдааны энэхүү дүгнэлт, түүний дагуу гаргасан АМГТГ-ын даргын шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан, Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн архивт хүлээлгэн өгөхийг “Хоргын чулуу” ХХК /Б.Мөнх-Эрдэнэ /-д даалгах.

д. Улаанбаатар хотын Налайх дүүрэгт нутагт орших “Ар налайх” шаврын ордод 2013 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан боловсруулалт, бүх төрлийн дээжлэлтийг геологич С.Алтангэрэл, Л.Бадамтулга нар, өрөмдлөгийн ажлыг “Хоргын чулуу” ХХК, байр зүйн зураглалын ажлыг “Жеммери” ХХК, технологи, физик механик, химийн шинжилгээг Барилга архитектур корпорацийн лаборатори, цацрагийн шинжилгээг Цөмийн болон цацрагийн хяналтын газрын Цацрагийн хяналт шинжилгээний лаборатори, дээрх гүйцэтгэсэн ажлуудын үнэн бодит байдал, чанарыг хянаж гаргасан дүгнэлтийг геологийн зөвлөх инженер Н.Зинэмэдэр болон “Хоргын чулуу” ХХК тус тус хариуцах.

ТАНИЛЦСАН:
ЭБМЗ-ИЙН ДАРГА Б.БААТАРЦОГТ

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:
ЭБМЗ-ИЙН САЛБАР
ХУРАЛДААНЫ ДАРГА Д.ГАНБАТ

БОЛОВСРУУЛСАН:
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Н.ОЮУНЦЭЦЭГ

*ЭБМЗ-ийн 2017 оны 07 дугаар*
*сарын 25-ны өдрийн хуралдааны*
*XX-13-06 дугаар дүгнэлтийн хавсралт*

MV-003978 тоот тусгай зөвшөөрлийн талбайн Ар налайхын шаврын ордын нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт

Хүснэгт №1

| № | Нөөцийн зэрэглэл блокийн дугаар | Блокийн талбай, $м^2$ | Ашигт малтмалын дундаж зузаан, м | Ашигт малтмалын нөөц, | |
|---|---|---|---|---|---|
| | | | | $м^3$ | тн (шаврын эзлэхүүн жин 1.85 тн/$м^3$) |
| 1 | B-1 | 20198 | 5.4 | 109069 | 178655 |
| 2 | B-2 | 23950 | 5.1 | 122145 | 202988 |
| 3 | B-3 | 19973 | 5.3 | 105857 | 160722 |
| 4 | B-4 | 21708 | 5.1 | 110711 | 174707 |
| 5 | C-1 | 99038 | 4.6 | 455575 | 749598 |
| 6 | C-2 | 72267 | 4.5 | 325202 | 514507 |
| **Бүгд нөөц B+C** | | **257134** | **5** | **1228558** | **1981176** |
| **Нийт бодитой нөөц (B)** | | **85829** | **5.2** | **447782** | **717071** |
| **Нийт боломжтой нөөц (C)** | | **171305** | **4.5** | **780776** | **1264105** |

"ХОРГЫН ЧУЛУУ" ХХК-Д


**МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,
Утас: 26 19 66, Факс: (976-51) 26 61 71,
E-mail: contact@mne.gov.mn, http://www.mne.mn


2019.02.15 № 13/956

танай ____________-ны №____________-т

Ерөнхий үнэлгээний дүгнэлт
хүргүүлэх тухай

Танайхаас боловсруулж ирүүлсэн Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт байрлах Налайх нэртэй ашигт малтмалын ашиглалтын MV-003978 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий талбайд орших "Шаврын ордыг ашиглах төсөл"-д "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, "Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам"-ын 3 дахь хэсгийг үндэслэн, байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлээ.

Ерөнхий үнэлгээний дүнгээр уг төсөлд аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзэв.

Төсөл хэрэгжүүлэгч нь Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудаст заасан нарийвчилсан үнэлгээний явцад тодруулах асуудлууд, онцгойлон анхаарах чиглэлийг харгалзан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, 2019 оны 4 дүгээр улиралд багтаан тус яаманд ирүүлэхийг үүгээр мэдэгдье.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудсыг хавсаргав.

ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ А.ЭНХБАТ

УХА0579 9084084

020675

## БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

# ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУУДАС

**2019 оны 02-р сарын 13** **Улаанбаатар хот**

**Төслийн дугаар** **Дугаар 2019/J023**

***Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг:*** “Хоргын чулуу” ХХК, регистрийн дугаар-5017386, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 12-р хороо, Жанжины 29 тоот.

***Төслийн нэр:*** Шаврын орд ашиглах

***Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр:*** Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт байрлах Налайх нэртэй ашигт малтмалын ашиглалтын MV-003978 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий талбайд хэрэгжинэ.

***Холбоо барих утас:*** +976-11-88228855.

***Орон нутгийн санал:*** Улаанбаатар хотын Налайх дүүргийн Засаг даргын 2019 оны 01-р сарын 23-ны өдрийн 04/127 тоот албан бичгээр ирүүлсэн санал, тус яамны 2019 оны 01-р сарын 18-ны өдрийн 06б/471 тоот лавлагаа зэргийг харгалзан үзэв.

| | Ерөнхий үнэлгээний гол шалгуурууд | Нийцсэн | Нийцээгүй | Нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай | Үндэслэл, тайлбар |
|---|---|---|---|---|---|
| Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн нийцэл | Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа байгаль орчныг хамгаалах болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн холбогдох заалт | | | Тийм | Нарийвчилсан үнэлгээний явцад хууль тогтоомжийн нийцлийг нарийвчлан тодорхойлох |
| Төрийн бодлого, шийдвэрийн нийцэл | Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Стратегийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн холбогдох заалт | Тийм | | | |
| Төслийн байршил, түүнтэй холбогдох шалгуурууд | Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх (урсац бүрэлдэх эх, ойн болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, хилийн хамгаалалтын бүс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар г.м) | | | Тийм | |
| | Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь хүний нөлөө, байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг, мэдрэмтгий эсэх | | | Тийм | |
| | Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд улс, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн, сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй газар байгаа эсэх | | | Тийм | |
| | Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсгэх эсэх | | | Тийм | |
| Төслийн байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээ | **Агаарын чанар** | | | | |
| | Бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгаруулах, эсэх | | | Тийм | |
| | Дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсгэх, эсэх | | | Тийм | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **Усан орчин** | | | | |
| | Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх, эсэх | | | Тийм | |
| | Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх | | | Тийм | |
| | Гадаргын болон газрын доорх усанд бохирдол үүсэх, эсэх | | | Тийм | |
| | **Хөрсөн бүрхэвч** | | | | |
| | Хөрсөн бүрхэвч эвдрэх, эсэх | | | Тийм | |
| | Хөрс бохирдуулах эсэх | | | Тийм | |
| | Хөрс доройтох, цөлжих эсэх | | | Тийм | |
| | **Ургамлан нөмрөг** | | | | |
| | Ургамалан нөмрөг, ой мод өртөх эсэх | | | Тийм | |
| | Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйлс өртөх, эсэх | | | Тийм | |
| | **Амьтны аймаг** | | | | |
| | Зэрлэг амьтдын амьдрах орчинг доройтуулах, эсэх | | | Тийм | |
| | Ховор, нэн ховор амьтан өртөх, эсэх | | | Тийм | |
| Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ | **Нутгийн оршин суугчид** | | | | |
| | Газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөх, эсэх | | | Тийм | |
| | Нутгийн оршин суугчдын нийгмийн байдалд сөрөг нөлөөлөлтэй, эсэх | | | Тийм | |
| | Нөлөөлөлд өртөж болзошгүй төв, суурин газар байгаа, эсэх | | | Тийм | |
| | Нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэх, эсэх | | | Тийм | |
| | **Түүх, соёлын биет өв** | | | | |
| | Сөрөг нөлөөлөлд өртөх түүх, соёлын үнэт зүйлс бий эсэх | | | Тийм | |
| | **Хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл** | | | | |
| | Нутгийн иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эсэх | | | Тийм | |
| | Төслийн бүх үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд эрсдэл үүсэх эсэх | | | Тийм | |

**Нэгдсэн дүгнэлт:**

**Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт байрлах Налайх нэртэй ашигт малтмалын ашиглалтын MV-003978 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий талбайд орших "Шаврын ордыг ашиглах төсөл"-д хийсэн Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлээр уг төсөлд батлагдсан аргачлалын дагуу Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзлээ.**

**Онцгойлон анхаарах зүйлс:**

1. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг батлагдсан Техник эдийн засгийн үндэслэлд тулгуурлан хийлгэх бөгөөд олборлолт, боловсруулалтын технологийн дараалллыг нарийвчлан тодорхойлж, технологийн сонголтод үнэлэлт дүгнэлт өгөх;

2. Төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, байгаль орчин /ургамал, хөрс, ус, амьтан, агаар/-д үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүний хамрах хүрээ, учруулах хохирлын хэмжээ, тархалтыг урьдчилан тооцож, нийлбэр үнэлгээ гарган төслийг экологи, эдийн засгийн үр ашигтайгаар хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар дүгнэлт гаргах;

3. Тухайн орд газрын гадаргын болон газрын доорх усны харилцан хамаарлыг нарийвчлан судалж, төсөл хэрэгжүүлэгчийн сонгосон аргаар байгаль орчин, хүний эрүүл мэндэд халгүйгээр тухайн ордыг ашиглах боломжтой эсэхийг тодорхойлж, дүгнэлт өгөх;

4. Шавар олборлох болон төслийн бүрэлдэхүүн хэсгээс ялгарах бохирдлын хэмжээ, түүний тархалт, нөлөөллийг хүрээг нарийвчлан тодорхойлж, зураглал үйлдэн тайланд хавсаргах;

5.Төслийн үйл ажиллагаанаас нөлөөлөлд өртөх талбайн хэмжээг тооцож, Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрыг урьдчилан торхойлж, хамгаалах арга хэмжээний төлөвлөлтийг төсөл

| |
|---|
| хэрэгжүүлэгч, орон нутгийн захиргааны байгууллагатай тохиролцон шийдвэрлэх; |
| 6. Ордын ашиглалт дууссаны дараах хаалтын нөхөн сэргээлт, мониторинг хийх төслийг боловсруулж, хаалтын ажлын каледарчилсан төлөвлөгөө, зардлын тооцоог урьдчилан тооцох; |
| 7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр/-г боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлыг эхний 5 жилээр тооцож ирүүлэх; |
| 8. "Байгаль орчныг хамгаалах тухай" хуулийн 10[1]-р зүйлд заасны дагуу төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд байгаль орчны төлөвлөгөөт аудитыг төслийн 2 дахь жилээс хийлгэх, аудитын дүгнэлт зөвлөмжийг холбогдох газруудад хүргүүлэх хугацаа, зардлыг тайланд тусгах; |
| 9. Нарийвчилсан үнэлгээ хийх явцад уг төсөл хэрэгжиснээр байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөллийн талаар болон БОННҮ-ний ажлын тайланг төсөл хэрэгжих хорооны ИНХ-аар хэлэлцүүлж, хурлын тэмдэглэл, шийдвэр болон дүүргийн Засаг даргын /ИТХ/ саналыг авч тайланд хавсаргах. |

**Заавал хэрэгжүүлэх шаардлагатай дээр дурдсан арга хэмжээг цаг хугацаанд нь ханган биелүүлээгүй тохиолдолд ерөнхий үнэлгээний дүгнэлтийг хүчингүй болгож, "Зөрчлийн тухай" хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу хариуцлага тооцдог болохыг анхаарна уу.**

| | |
|---|---|
| Ерөнхий үнэлгээ хийсэн:<br>**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ШИНЖЭЭЧ**<br><br>**Д.ШИЖИР-ЭРДЭНЭ** | Ерөнхий үнэлгээний үр дүнг зөвшөөрсөн:<br>**"Хоргын чулуу" ХХК-ийн захирал**<br><br>**Б.Мөнх-Эрдэнэ** |

БАТЛАВ:

БОАЖЯ-НЫ ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ П. ЦОГТСАЙХАН

ШҮҮМЖ БИЧСЭН:

БОАЖЯ-НЫ ШИНЖЭЭЧ Д.ШИЖИР-ЭРДЭНЭ

# УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГ ОРШИХ “ХОРГЫН ЧУЛУУ” ХХК-ИЙН MV-003978 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ “АР НАЛАЙХ ШАВРЫН ОРД”-ЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА:

“АШИД-АНАНДА” ХХК, ЗАХИРАЛ С.УНДРАХ

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:

“ХОРГЫН ЧУЛУУ” ХХК, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б. ЕРЭНБАТ

УЛААНБААТАР ХОТ

2019 он

БАТЛАВ:

БОАЖЯ-НЫ ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ П. ЦОГТСАЙХАН

# УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГ ОРШИХ "ХОРГЫН ЧУЛУУ" ХХК-ИЙН MV-003978 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ "АР НАЛАЙХ ШАВРЫН ОРД"-ЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**/Ашиглалтын 5 жил/**

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА:

"АШИД-АНАНДА" ХХК, ЗАХИРАЛ С.УНДРАХ

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:

"ХОРГЫН ЧУЛУУ" ХХК, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б. ЕРЭНБАТ

УЛААНБААТАР ХОТ

2019 он

ОБЕГ - ын даргын 2016 оны 03 - р сарын 25 - ны
өдрийн А/75 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

БАТЛАВ .
“ХОРГЫН ЧУЛУУ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ . . . . . Б.МӨНХ-ЭРДЭНЭ

2022 оны . . . . . .сарын . . . . . . . өдөр

ЗӨВШӨӨРСӨН .
ОБЕГ-ЫН ДЭРГЭДЭХ УУЛ УУРХАЙН
АВРАХ 09 ДҮГЭЭР АНГИЙН ЗАХИРАГЧ,
ХУРАНДАА Д . ГАНТУЛГА

2022 оны . . . . . . сарын . . . . . . .өдөр

# УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГТ ОРШИХ АР НАЛАЙХ НЭРТЭЙ ТООСГОНЫ ШАВРЫН ОРДЫН ИЛ УУРХАЙН АЮУЛЫН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

АТЗ-ийн дугаар MV-003978

Хянасан :
Уул Уурхайн аврах 09-р ангийн техникийн албаны дарга, аврах ажиллагааны удирдагч, ахмад Д . Баяржаргал

Хянасан :
“Хоргын чулуу” ХХК-ийн зөвлөх Б.Түмэн-од

Боловсруулсан:
“Хоргын чулуу”-ийн тоосгоны шаврын ил уурхайн инженер геологи О.Оюундарь

2022 он

**2022 ОНЫ АЮУЛЫН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ**


**I. БҮС НУТГИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ** ..... 2

**I.1. Аж ахуйн нэгжийн эрх** ..... 2

"Хоргын чулуу" ХХК нь Монгол улсын 9011341106 тоот бүртгэлийн дугаар бүхий аж ахуйн нэгжийн гэрчилгээтэй..... 2

**I.2. Орд ашиглах тусгай зөвшөөрөл** ..... 2

**I.3. Эдэлбэр газрын хил хязгаар** ..... 2

Хүснэгт № 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн солбицлууд..... **Error! Bookmark not defined.**

**I.4. Ордын судлагдсан байдал** ..... 2

**I.5. Гидрогеологи** ..... 3

**I.6. Ордын геологийн тогтоц** ..... **Error! Bookmark not defined.**

Хүснэгт № 2. Ил уурхайн ажлын горим ..... 7

Хүснэгт № 3. Ил уурхайн ажиллах горим ..... **Error! Bookmark not defined.**

**Тоног төхөөрөмжийн сонголт** ..... 7

Уурхайн үндсэн тоног төхөөрөмжүүд сонголт..... 8

Хүснэгт № 4. Тоног төхөөрөмжийн жагсаалт ..... **Error! Bookmark not defined.**

**III. УУЛЫН АЖЛЫН МЕХАНИКЖУУЛАЛТ** ..... 10

**Авто тээвэр** ..... 13

**IV. ХАРИЛЦАА ХОЛБОО, ХЯНАЛТ, ДОХИОЛОЛ** ..... 17

**ИЛ УУРХАЙН УС ТАТАХ, ШҮҮРҮҮЛЭХ АЖИЛ** ..... 17

**V. ОСЛЫН ҮЕД АЖИЛЛАХ ЕРӨНХИЙ ДҮРЭМ.** ..... 18

1. Аваар гарах нөхцөл. ..... 18

2. Аваар осол гарсныг мэдээллэх..... 18

**VI. АВААР УСТГАХ АЖЛЫН ХАРИУЦЛАГАТАЙ УДИРДАГЧИЙН ҮҮРЭГ** ..... 26

**VII. ЕРӨНХИЙ ЗААВАРЧИЛГАА** ..... 29

**VIII. ГАУС арга хэмжээ ба гал гарсан үед авах арга хэмжээ** ..... 30

VIII.2 Хориглох болон анхаарах зүйл: ..... 31

IX.2 Дэмжлэг үзүүлэх ойролцоох аж ахуй нэгжийн мэдээлэл: ..... 32

IX.3 Ааварыг устгах бодлого: ..... 32

"Ар налайх"-ын ил уурхайн аваар ослын үед ажиллах схем ..... **Error! Bookmark not defined.**

БАТЛАВ.

НАЛАЙХ ДҮҮРГИЙН ХОТ ТӨЛӨВЛӨЛТ НОГООН ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН УДИРДАГЧ БӨГӨӨД ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

С.ТУНГАЛАГ

БАТЛАВ.

"ХОРГЫН ЧУЛУУ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Б.ЕРЭНБАТ

**ХАЯГДАЛ УСЫГ БАЙГАЛЬД ШУУД НИЙЛҮҮЛЖ БАЙГАА ХУУЛИЙН ЭТГЭЭДТЭЙ БАЙГУУЛАХ УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ГЭРЭЭ**

2022 оны 06 дугаар сарын 21 өдөр №03 Налайх дүүрэг

Нэг. Еренхий зүйл

Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу Туул голын сав газрын захиргааны гаргасан 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 97 дугаартай хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг үндэслэн Нэг талаас: Ус ашиглуулагчийг төлөөлж дүүргийн Засаг даргын орлогч Санжаа овогтой Тунгалаг, нөгөө талаас ус бохирдуулагчийг төлөөлж Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3 дугаар хороо байрлах 9011002065 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ, 5017386 тоот регистрийн дугаартай "Хоргын чулуу" ХХК-ийг төлөөлж захирал албан тушаалтан Б овогтой Ерэнбат нар ус бохирдуулсаны төлбөр, нөхөн төлбөр төлөх талаар харилцан тохиролцон энэхүү гэрээг 1 /нэг/ жилийн хугацаатай байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус бохирдуулагч нь хаягдал усыг "Хүрээлэн байгаа орчин, Усны чанар. Хаягдал ус Ерөнхий шаардлага" MNS 4943:2015 стандартын норматив шаардлагад нийцүүлэн байгальд шууд нийлүүлнэ.

2.2. Ус бохирдуулагч нь Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усны чанарыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлсэн тохиолдолд ус бохирдуулсны төлбөр, стандартын норматив шаардлагад нийцүүлээгүй тохиолдолд ус бохирдуулсны нөхөн төлбөрийг хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын хэмжээнээс хамааран 2-5 дахин шатлан өсгөх хэлбэрээр тооцож төлнө.

2.3. Төлбөр төлөгч нь Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усан дахь бохирдуулах бодист ногдох төлбөр, нөхөн төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд төлнө.

2.4. Ус бохирдуулагч нь дараах мэдээллийг улирал тутамд Сав газрын захиргаа, харьяа татварын албанд хүргүүлнэ. Үүнд:

2.4.1. Хаягдал ус нийлүүлдэг хүн, хуулийн этгээдийн нэр,

2.4.2. Цэвэрлэх байгууламж болон зөөврийн машинд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ,

2.4.3. Байгальд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ,

2.4.4. Хаягдал усанд байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор хийлгэсэн шинжилгээний дүн,

2.4.5. Ус бохирдуулсны төлбөр төлсөн тайлан.

Гурав. Ус ашиглуулагчийн эрх, үүрэг

3.1. Ус бохирдуулагчийг мэдээ, мэдээлэл, мэргэжил аргазүйн удирдлагаар хангаж, хяналт тавина.

3.2. Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8 дахь заалтад заасны дагуу Сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх

заалтад заасны дагуу Сум, дүүргийн Засаг дарга нь нутаг дэвсгэртээ хаягдал ус зайлуулах цэг тогтооно.

3.3. Сав газрын захиргаа болон сум дүүргийн Засаг дарга нь хаягдал усыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлэн цэвэрлэсэн, дахин ашигласан ус бохирдуулагчийг ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх жагсаалтыг гаргана.

3.4. Сав газрын захиргаа болон дүүргийн Засаг дарга нь хаягдал ус хаях, зайлуулах шаардлагыг зөрчсөн ус бохирдуулагчийн хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг цуцална.

Дөрөв. Ус бохирдуулагчийн эрх, үүрэг

4.1. Ус бохирдуулагч нь Сав газрын захиргаанаас мэргэжил, арга зүйн зөвлөгөө авах, хаягдал ус хаях, зайлуулах цэг тогтоолгох, ногдуулсан ус бохирдуулсны төлбөр болон нөхөн төлбөрийн хэмжээг үндэслэлгүй гэж үзвэл дээд шатны байгууллагад гомдол гаргах эрхтэй.

4.2. Ус бохирдуулагч нь үйл ажиллагаандаа энэхүү гэрээг болон холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, норм, норматив, ТЭЗҮ, зураг төсөл, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мөрдөж ажиллана.

4.3. Ус бохирдуулагч нь хаягдал усны ээлхүүнийг тодорхойлох хэмжих хэрэгсэл /тоолуур/-ийг "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"-д заасны дагуу хаягдал усны шугамын гаргалгаан дээр суурилуулах тоолуур нь гаргалгааны шугамын голчтой адил байх бөгөөд мэдрэгчийн хийц нь хаягдал усны найрлагаас хамааран өөрчлөгдөх, эвдрэх, гэмтэх зэрэг эрсдэлээс хамгаалагдсан эд ангиар хийгдсэн байх шаардлагад нийцүүлэн суурилуулна.

Тав. Бусад

5.1. Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

5.2. Ус бохирдуулагч нь ус бохирдуулсны төлбөр, нөхөх төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

5.3. Энэхүү гэрээг сунгах, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой асуудлыг 2 тал харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

5.4. Энэхүү гэрээтэй холбогдон гарсан аливаа маргааныг эвийн журмаар шийдвэрлэхэд эрмэлзэх бөгөөд эс тохиролцвол иргэний журмаар шүүхээр шийдвэрлүүлнэ.

Зургаа. Давагдашгүй хүчин зүйлс

6.1. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл гэх мэт/-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /нөхөн төлбөр, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

6.2. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл бий болсныг нотолно.

**Гэрээ байгуулсан:**

| Ус ашиглуулагчийг төлөөлж: | Ус бохирдуулагчийг төлөөлж: |
| --- | --- |
| Засаг даргын Тамгын газрын Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн ........................../Б.Батчимэг/ | "Хоргын чулуу" ХХК-ийн ажилтан ............................/..................... / |
| Хаяг: УБ, Налайх дүүрэг, 2 дугаар хороо, | Хаяг:..................................... |
| Утас: 88139901 | Утас:..................................... |

УЛААНБААТАР ХОТ ХОРГЫН ЧУЛУУ ХХК 9020030966 5017386 УБТТ3229

БАТЛАВ
ЧАНДМАНЬ НАЛАЙХ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ ........ Б.БОЛДБААТАР
2022 оны 06 сарын 26 өдөр

БАТЛАВ
Хоргын чулуу ХХК
Захирал ........ Б. Мөнх-Эрдэнэ.
2022 оны 5 сарын 26 өдөр

УЛААНБААТАР ХОТ
ХОРГЫН ЧУЛУУ
9020030966
5017386 УБТТ3229

## АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН БОХИР УС ТАТАН ЗАЙЛУУЛАХ ГЭРЭЭ

2022 оны 05 сарын 26-ны өдөр № Б/09. Налайх дүүрэг

### Нэг. Ерөнхий зүйл

1.1 Монгол улсын "Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль"-ийн 13-р зүйлийн 13.2 дахь заалт, Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах аж ахуйн харилцааны дүрмийн 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн, Нэг талаас "Чандмань-Налайх" ОНӨААТҮГ /цаашид Хангагч гэх/-ыг төлөөлж Хуулийн зөвлөх ажилтай Л.Өнөрмаа, нөгөө талаас ........Хоргын чулуу ХХК........ /цаашид Хэрэглэгч гэх/- төлөөлж ........Захирал........ ажилтай ........Б. Мөнх-Эрдэнэ........ нар нь 2022 оны 05 сарын 26-ны өдрөөс 2023 оны 05 сарын 26-ны өдөр хүртэл 1 жилийн хугацаатай дор дурдсан нөхцөлийг биелүүлж ажиллахаар харилцан тохирч энэхүү гэрээг байгуулав.РД: 5017386

### Хоёр. Хэрэглэгчийн эрх үүрэг

**2.1 Хэрэглэгч нь дараах эрхтэй**

2.1.1 Гэрээний дагуу бохир ус нийлүүлэх үйлчилгээ хийнэ.
2.1.2 Хангагч болон ажилтнуудын үйл ажиллагааны талаарх санал хүсэлт, гомдлыг "Чандмань-Налайх" ОНӨААТҮГ-ын диспетчерийн 70233310, 89953310 утсаар болон байгууллагын удирдлагад мэдээлэх, гомдол гаргах.
2.1.3 Өөрийн эзэмшлийн бохир ус нийлүүлэх үйлчилгээтэй холбоотой асуудлаар хангагчаас мэргэжлийн туслалцаа хүсэх, зөвлөгөө авах
2.1.4 Хэрэглэгч нь Налайх дүүрэг 5 дугаар хорооны цэвэрлэх байгууламжийн тогтоосон худагт бохирыг нийлүүлнэ.
2.1.5 Хэрэглэгч нь бохир ус хүлээн авах ажилтны заасан худагт бохирыг нийлүүлж, баримтжуулан баримт авна.

**2.2 Хэрэглэгч нь дараах үүрэгтэй**
2.2.1 Хэрэглэгч нь бохир ус нийлүүлэх төлбөрийг тухай бүр төлнө. /гэрээ хийхэд урьдчилан 30тн бохирын төлбөрийг төлнө.
2.2.2 Хангагч байгууллагатай заасан хугацаанд гэрээ байгуулах, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх
2.2.3 Хэрэглэгч өөрийн байршил, харилцагч банк, дансны дугаар, хаягийн бүртгэл солигдох бүрд гэрээнд тодотгол хийлгэх
2.2.6 Хэрэглэгч нь бохир усыг заасан худагт хийх ба бохир ус нийлүүлэх стандарт "MNS.6561:2015"-д стандартын шаардлагад нийцсэн бохир усыг нийлүүлнэ. Химийн бодис агуулсан буюу усанд уусахгүй бүхэл биет агуулсан бохир ус нийлүүлэхийг хориглоно.

### Гурав. Хангагчийн эрх, үүрэг

**3.1 Хангагч нь дараах эрхтэй.**
3.1.2 Хэрэглэгчийн бохир ус нийлүүлэх стандарт шаардлага талаар мэргэжлийн заавар зөвлөгөө өгөх
**3.2 Хангагч нь дараах үүрэгтэй**
3.2.1 Хангагч нь хэрэглэгчийн хүсэлтээр төлбөртэй үйлчилгээг үзүүлэх
3.2.2 Хэрэглэгч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах, учирсан хохирлоо төлөхийг шаардах.
3.2.3 Хангагч нь хэрэглэгчийн санал гомдлыг хүлээн авч, 24 цагийн дотор барагдуулна.

3.2.4 Хэрэглэгчийн захиалга болон дуудлагаар засвар үйлчилгээний ажлыг батлагдсан үнэ тарифаар хийнэ.
3.2.5 Ажилтны буруугаас хэрэглэгчийг илүү төлбөр төлүүлсэн, төлөх нөхцөл байдалд хүргэсэн бол алдааг залруулах, дараа сарын төлбөрт шилжүүлэх

## Дөрөв. Төлбөр тооцооны журам

4.1 Гэрээний баталгаа болгож $30^3$ бохир ус нийлүүлэх урьдчилгаа төлбөрийг /30м$^3$ 2600+НӨАТ 10%+баримтын үнэ 86020 / "Чандмань Налайх" ОНӨААТҮГ-т тушаана.

4.2 Хэрэглэгч нь бохир усыг заасан худагт хийх ба 1тн бохир усыг 2600 /НӨАТ-гүй/ төгрөгөөр тооцож, гэрээний дагуу төлбөр тооцоо хийнэ.

4.3 Үйлчилгээний төлбөрийг тухайн сарын 25-ны дотор "Чандмань Налайх" ОНӨААТҮГ-ын ХАС БАНК- 5000192357 дансанд тушаана.

4.3 Үйлчилгээний сар бүрийн төлбөрийг тухайн сарын 25-ны өдөр төлөөгүй хэрэглэгчдэд хугацаа хэтэрсэн хоног тутамд төлбөрийн үнийн дүнгийн 0,5%-иар тооцон алданги тооцно.

## Тав.Талуудын харилцан хүлээх үүрэг хариуцлага

5.1 Хоёр тал Иргэний хууль, Усны тухай хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Хэмжлийн нэгдмэл байдлын тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ.
5.2 Гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг хоёр тал хамтран шийдвэрлэх ба тохиролцоогүй тохиолдолд хуулийн байгууллагад хандан шийдвэрлүүлнэ.

## Зургаа. Маргаан шийдвэрлэх

6.1 Хангагч хэрэглэгчийн хооронд гарсан хэрэглээ, төлбөр тооцоотой холбогдсон маргаантай асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
6.2 Гэрээний үүргээ биелүүлээгүй хоёр тал харилцан эс зөвшөөрвөл хуулийн байгууллагаар шийдүүлнэ.

## Долоо: Бусад зүйл

7.1 Аж ахуйн гэрээг 2% үйлдэж талууд авна.
7.2 Хэрэглэгч өөрийн хүсэлтээр гэрээг цуцалж болох ба энэ тухай хангагчид 14 хоногийн өмнө мэдэгдэнэ.
7.3 Гэрээг цуцлахдаа үйлчилгээний төлбөрөө бүрэн барагдуулсан байна.
7.4 Гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг хоёр тал хамтран шийдвэрлэх ба тохиролцоогүй тохиолдолд Хуулийн байгууллагад хандан шийдвэрлүүлнэ.
7.5 Үнэ тарифт өөрчлөлт орох бүрд хангагч энэ тухай хэрэглэгчдэд 30 хоногийн өмнө албан мэдэгдэл болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдэгдэх ба үнэ тарифын хэрэгжилт нь эрх бүхий байгууллагын тушаал шийдвэрт заасан хугацаанаас эхлэн мөрдөгдөнө.
7.6 Гэрээнд хоёр тал харилцан тохиролцож нэмэлт өөрчлөлт оруулж болно.
7.7 Гэрээг жил бүр сунгаж, тодотгол хийнэ.

| | |
|---|---|
| ХАНГАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: | ХЭРЭГЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ |
| ЕРӨНХИЙ НЯ-БО | Захирал |
| ........................../Л.Алимаа/ | ......................... Б.Цогт-Эрдэнэ. |
| ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН | Email: hargyn.chuluu.hhk@gmail |
| ........................../Л.Өнөрмаа/ | |
| Утас: 89155354, 89022793 | Утас: 88228855, |
| Хаяг: Налайх дүүрэг, 2 хороо, Дамдины гудамж | Хаяг: НД 3 хороо Тоосгоны үйлдвэр. |
| 2022 оны 05 сарын 26 өдөр | 2022 оны 05 сарын 26 өдөр |

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohztl@gmail.com

# СОРИЛТЫН ДҮН

| | |
|---|---|
| Дугаар он/№ | : 2022/ Ц-163 |
| Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас | : "Хоргын Чулуу" ХХК |
| Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал | : Б.Батхишиг, БОХЗТЛ |
| Сорьцын тоо,төрөл | : 1, ус |
| Сорьцыг авсан огноо | : 2022.09.20 |
| Сорьцын тодорхойлолт | : Усны сорьц |
| Шинжилгээний аргын стандарт | **MNS ISO 6836:2020, MNS 6833:2020**<br>**MNS ISO 7150-1:2006, ,MNS 6779:2019**<br>**MNS 6834:2020, MNS ISO 6878:2001**<br>**MNS 4430:2005, MNS 6272: 2011** |
| Шинжилсэн огноо | : 2022.09.120-2022.10.03 |
| Хуудасны тоо | : 1 /2 |
| Үр дүн | : 1 |

| Сорьцын нэр | Ж/б мг/л | ПИЧ мг/л | $NH_4$ мгN/л | $NO_2$ мгN/л | $NO_3$ мгN/л | $PO_4$ мгP/л | Fe мг/л | F мг/л |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Найлайх дүүрэг 3-р хороо Худгийн ус | 6.6 | 0.6 | 0.90 | 0.009 | 0.22 | 0.035 | 0.02 | 1.16 |
| **MNS 0900:2018** | - | - | **1.5** | **1.0** | **50** | **3.5** | **0.3** | **0.7-1.5** |

Тайлбар: Ж/б- Жинлэгдэгч бодис, ПИЧ-Перманганатын Исэлдэх Чанар, ИЛР-Илрээгүй

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер: Б.Жавзандулам

Хянаж баталгаажуулсан инженер: Ц.Мийдүв

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

MNAS
Accreditation system
TL 08
MNS ISO/IEC

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР**
**БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН**
**ТӨВ ЛАБОРАТОРИ**

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohztl@gmail.com

БАЙГАЛЬ
ОРЧИН ХЭМЖИЛЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ

## СОРИЛТЫН ДҮН

| | |
|---|---|
| Дугаар он/№ | : 2022/ Ц-163 |
| Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас | : "Хоргын Чулуу" ХХК |
| Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал | : Б.Батхишиг, БОХЗТЛ |
| Сорьцын тоо,төрөл | : 1, ус |
| Сорьцыг авсан огноо | : 2022.09.20 |
| Сорьцын тодорхойлолт | : Усны сорьц |
| Шинжилгээний аргын стандарт | **MNS ISO 10523:2001, MNS ISO 7888:1999, MNS 6271:2011, MNS 4424:2005, MNS 1097:1970** |
| Шинжилсэн огноо | : 2022.09.20-2022.10.03 |
| Хуудасны тоо | : 2 /2 |
| Үр дүн | : 1 |

| Сорьцын нэр | pH | EC µS/см | $SO_4$ мг/л | Cl мг/л | Ca мг/л | Mg мг/л | Na+K мг/л | $HCO_3$ мг/л | Эрд мг/л | Хат мг-экв/л |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Найлайх дүүрэг 3-р хороо Худгийн ус | 7.59 | 1321 | 91.9 | 115 | 50.8 | 24.6 | 255 | 587 | 1124 | 4.55 |
| **MNS 0900:2018** | **6.5-8.5** | **1000** | **500** | **350** | **100** | **30** | - | - | - | **7.0** |

Тайлбар: EC - цахилгаан дамжуулах чанар, Хат-Хатуулаг, Эрд-Эрдэсжилт

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер: Б.Жавзандулам

Хянаж баталгаажуулсан инженер: Ц.Мийдув

Стандартчилал итгэмжлэгдсэн лаборатори TL № 08

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohztl@gmail.com

# СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/ № : 2022/ 514
Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : " Хоргын чулуу " ХХК
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : Б.Батхишиг, агаарын хэсгийн техникч
Дээжийн тоо, төрөл : 1, хөрсний сорьц
Хүлээн авсан огноо : 2022.09.20
Дээжийн тодорхойлолт : Улаанбаатар хот-Налайх дүүрэг
Шинжилгээний аргын стандарт : САЗ А01:2022
Шинжилсэн огноо : 2022.09.22
Хуудасны тоо : 1/1
Үр дүн:

| № | Сорьц авсан цэгийн нэр | Кадьми (Cd) | Хар тугалга (Pb) | Мөнгөн ус (Hg) | Хром (Cr) | Цайр (Zn) | Зэс (Cu) | Кобальт (Co) | Стронци (Sr) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мг/кг | | | | | | | |
| 1 | Бааюу орчмоос | <0.005 | 26.7 | <0.005 | <0.005 | 54.5 | 29.3 | 22.4 | 320.7 |
| MNS 5850:2019 / ЗДХ/ | | 3 | 100 | 2 | 150 | 300 | 100 | 50 | 800 |

Шинжилгээ гүйцэтгэсэн :
Хөрсний хэсгийн инженер Д.Баярхулан

Хянаж баталгаажуулсан :
Хөрсний хэсгийн инженер Б.Даваасүрэн

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн дээжинд хүчинтэй

MNAS
Accreditation system
TL 08
MNS ISO/IEC

# ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
# БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohztl@gmail.com

БАЙГАЛЬ
ОРЧНЫ ХЭМЖИЛЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ

## СОРИЛТЫН ДҮН

| | |
|---|---|
| Дугаар он/№ | : 2022/А-277 |
| Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас | : "Хоргын Чулуу" ХХК |
| Дээжийг авсан хүний нэр, албан тушаал | : Б.Батхишиг агаарын хэсэг |
| Дээжийн тоо, төрөл | : 2 агаар ,2 дуу чимээ |
| Сорьц авсан огноо | : 2022.9.20 |
| Дээжийн тодорхойлолт | : Налайх дүүрэг 3-р хороо тоосгоны үйлдвэр |
| Шинжилгээний аргын стандарт | : MNS 0017-2-5-12:2021, MNS 0017-2-5-11:2021 САЗ А07-2016 |
| Шинжилсэн огноо | : 2022.9.27 |
| Хуудасны тоо | : 1/1 |

Үр дүн :

| № | Сорьц авсан цэг | Сорьц авсан өдөр | Сорьц авсан цаг | Хүхэрлэг хий мг/м$^3$ | Азотын давхар исэл мг/м$^3$ | Нийт Тоос /TSP/ мг/м$^3$ | Дуу чимээ /ДБА/ |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бааюу орчим | IX/20 | 14:05 | 0.017 | 0.021 | 0.074 | 45 |
| 2 | Ажилчдын кемп | IX/20 | 14:30 | 0.019 | 0.026 | 0.078 | 49 |
| **Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 (20 минутын хэмжилт)** | | | | **0.450** | **0.200** | **0.500** | **60** |

Шинжилгээ гүйцэтгэсэн:
Байгаль орчны шинжилгээний инженер Э.Оюунтуяа

Хянаж баталгаажуулсан:
Байгаль орчны шинжилгээний хэлтсийн дарга Б.Бархасрагчаа

Стандартчилал хэмжил зүйн лаборатори TL 08

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй

БАТЛАВ
НАЛАЙХ ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ ОНӨААТҮГ-ЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.НАЯНБАЯР

БАТЛАВ
Доржбинчүүлэгч ХХК
............................/.............................../
БРД: 7017386 .

**ХОГ ХАЯГДЛЫГ АЧИЖ ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ**

20 22 оны 05 сарын 26 өдөр № 2205010 Налайх дүүрэг

## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

**ЗОРИЛТ:**Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах, ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх харилцааг зохицуулах, аж ахуйн нэгж байгууллага, ХХЭрхлэгч нэг бүрийн үүрэг хариуцлагыг тодорхойлж дүгнэх, Монгол Улсын Хог хаягдлын тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Нийслэлийн ИТХ-ийнТэргүүлэгчдийн 2009 оны 63-р тогтоолоор батлагдсан "Хот тохижилт,цэвэрлэгээний талаар албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дагаж мөрдөх журам","Журамд өөрчлөлт оруулах тухай" Нийслэлийн ИТХ-ийн 2012 оны 61-р тогтоол, Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөнчийн Хурлын 2021 оны 07/02 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхэд оршино.

